

**«НӨЛӨӨТ ТОЛИНД ТУССАН  
ДҮРС»**

Накац Фумихико «Чингисээс болсон  
адал явдал» Токио. 1984. Х-233.

Н. Фүмихикогийн бичсэн «Чингисээс болсон адал явдал» хэмээх туужийг 1984 онд Японы «Кадокава» хэвлэлийн газраас хэвлэн гаргажээ. Зохиогч «уг туужийн үйл явдал, баатрууд нь бодит бус, зохиомол болно» (233-р тал) гэж бичсэнээс үзвэл уг бүтээл цэвэр уран зохиолын хэлбэрээр бичигджээ гэж ойлгохоос өөр аргагүй юм. Гэхдээ зохиолд Монголын эртний болоод өнөөгийн түүх, соёл, зан заншилтай холбогдох бодит тоо баримтыг үндэслэн дурдсан нэлээд зүйл байгаа нь зохиогчийн өгүүлсэнтэй туужийн агуулгыг зөрчилдүүлэхэд хүргэжээ. Жишээ нь: «... Үнэндээ байгалийн баялагаар нэн арвин, жишээлбэл төмрийн хүдэр, зэс, нүүрс, молибден, хөнгөн цагаан, хаш, болор зэрэг элдэв баялагтай, өргөн уудам газар нутагтай нь харьцуулахад хүн ам цөөн ч монголчууд их хөдөлмөрч хүмүүс, уран гартай, авьяаслаг сайн чанарын ажиллах хүчинтэй гэхэд болно. Юунаас ч илүү чухал нь залуучууд ихтэй явдал юм. Өнгөрсөн жилийн (зохиогч 1983 оныг хэлсэн бололтой. -Ц. Б.) статистикийн мэдээгээр 35 хүртлэх насны залуус хүн амын 75 хувийг эзэлж байна» (23-р тал), «Монгол хүүхдүүд 3 нас хүрмэгц л морь унадаг. Морины уралдаан нь 1 настай буюу дааганы, 2 настай буюу шүдлэн, 3 настай буюу хязаалангийн гэсэн төрлүүдээр явагддаг бөгөвд хамгийн сүртэй нь нас гүйцсэн морьдын (6-гаас дээш насны бүх морь) ...40—45 км-ийн уралдаан байдаг. Улаанбаатарын ойролцоох талд болдог энэ уралдаанд жил бүр 500 — 600 морь ордог» (75-р тал) гэх мэтээр бичсэн нь манай орны амьдралыг японы уншигчдад танин мэдүүлэх ач холбогдолтой боловч уран зохиолын төлөвшиж тогтсон хэлбэрээс хэт хөндийрөн, «баримтын халил» болж байна.

Гэвч хэргийн гол, асуудлын цөм нь үүнд бус, Н. Фумихико уран зохиолын ургуулан бодохын эрх чөлөөг хэтрүүлэн эдэлж цөөн бус газар түүхийн үнэнээс тойрсон буюу дэгсдүүлэн гуйвуулсан явдалд байгаа юм.

БНМАУ-ын өнөөгийн амьдрал, манай улс орны түүхийн мэдлэгээр хомс дулимаг японы болон бусад орны уншигчдад уг тууж нилээд сонирхолтой, «жинхэнэ адал явдалт» (магадгүй Шерлок Холмсын 30 хиолоос ч илүү байж...) зохиол болсон мэт сэтгэгдэл төрүүлж болох авч монгол судлаачид болон Монголыг сайн мэдэх хүмүүс, ялангуяа монголчуудын хувьд мушгин завхруулж, хялбархнаар адал явдалчил сан нь эрүүл дүрсийг нөлөөтэй толинд харсан мэт болгож буй бөгөөд эл тухай өгүүлэхийн өмнө бид зохиолын гол үйл явдлыг авч ярья: Монгол судлалаар «Японд тэргүүн зэрэгт ордог, профессор Сунахара - гэрийнхээ ойролцоох цэцэрлэгт алагдсан байв. Түүний ахлан явах ёстой байсан Монголд очих Японы соёлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд зохиолын гол баатар, адал явдлын зохиолч Шин, монгол судлагч Анами, Гадаад хэлний дээд сургуулийн аспирант Янагида, Япон-Монголын найрамдлын нийгэмлэгийн нарийн бичгийн дарга Исэзаки нар оржээ.

Японы зүүн хойт нутгийн Хирайзүмигээс эсрэг талын их хүчинд автан амь зулбан умар зүг ойж зугтсан, цэргийн бослогын удирдагч, домогт баатар Ёшизүнэгийн үнэн түүх, мөн Ешизүнэ нь сүүлд Монголд очиж Чингис хааны дүрээр тодорсон буй зохиолын өөр нэг баатар, дээр нэр гарсан профессор Сунахарагийн шавь Янагидагийн мугуйд-явдалд зохиолын зангилаа оршиж байна. Сүнахара нь Ёшизүнэ, Чингис хоёр бол нэг хүн гэдгийг нотлохоор улайран хөөцөлдөж байгаа шавийнхаа үйл ажиллагааг буруутган зэмэлж, тэг - тэгсээр аспирант шавь Янагидагийн гарт харамсалтайгаар амь хохирч буйг түүнд<sup>1</sup> үзүүлжээ. Чухам үүнтэй зохиолын нэр холбоотой болов уу. Номын 147-р талд бичсэнийг үсэгчлэн иш татваас: «Нууц товчоонд... Жамуха нь ВАН хаанд хэлэхдээ:

Хан! Хан! би бол хамаагүй хол нисэхгүй

Хайргуна шувуу мэт хамт нэг газар байна.

Харин миний анд Тэмүжин бол харьж нисэх шувуу мэт

Хааш яаш урван одно

гэсэн нь би бол үргэлж тантай ойр байх нэг төрлийн хүн. Харин Чингис хаан бол нүүдлийн шувуу мэт хэзээ нэг цагт хаашаа ч явчихаж магадгүй хүн шүү гэдгийг сануулсан зүйл гэж ухаж (Японы түүхчид—Ц. Б) тайлбарладаг. Чингис монгол бус өөр үндэстний хүн байснаас ингэж хэлэгджээ хэмээн зохиогч эрээ цээргүй номчирхож, Чингисийг япон үндэстний төлөөлөгч буюу чухам хэлбэл Ешизүнэ болгохдоо уг жишээг «хань татсан» нь түүхэнд харшилж байна.

Будаач будаач гэхээр сахлаа будав гэгчийн үлгэрээр зохиогч цааш хэт даварчээ. Номын дэд зэрэг өөр нэг баатар, Монголын шинэ үеийн түүхийг судлагч Анами хэмээгч Монголын Ардын хувьсгалын жолоодогч Сүхбаатарыг алах заавар өгсөн хүн бол Ленин бөгөөд хэдийгээр нас залуу ч асар богино хугацаанд төр улсаа байгуулан, гарамгай удирдаж чадсан Сүхбаатарын суут авьяас, 700 жилийн өмнө дэлхийг байлдан дагуулсан Чингисээс хувь илүү ухаан билгээс нь айхдаа Ленин тийм заавар өгсөн гэж ярьж, энэ нь Зөвлөлтийн түүхийн хөмрөгийн «баримт бичгээр» батлагдаж байгаа мэтээр дүрслэн (150, 162-р тал) үзүүлсэн байна.

Энд ноцтой нь Октябрийн социалист их хувьсгалын аугаа суут соён гийгүүлэгч үзэл санааны нөлөө нөөлгөнд мандсан Монгол Ардын Хувьсгалын цогт манлай, Ардын нам, ардын төр, хувьсгалт цэрэг армийг зохион байгуулагч Сүхбаатарын их Лениний хамт Монгол-Зөвлөлтийн найрамдлын тулгын чулууг тавьж дархалсан түүхэн үнэнийг чингэж бүдүүлгээр гуйвуулж буй зохиолын баатар Янагида, Анами нарын хорхой үзэл бодлыг номын зохиогч Фүмихико уншигчдад ойлгогдохоор бүрнээ хуваалцаж байгаа явдал юм.

Ер нь гэж хэлэхэд энэ мэт үзэл бодлоор нэвтэрсэн зохиол нэрт зүйлс нь олон улсын харьцаанд шинэ сэтгэлгээ өрнөн дэлгэрч буй өнөөгийн дэлхий гаригийн нөхцөл байдалд сэжиг эргэлзээ төрүүлэх төдийгүй улс түмний найрамдал, бие биенээ харилцан ойлгож, ойртох үйл явцад аюлтай бөгөөд номын далай дахь их цэцэрлэгт ургасан хорт өвс болдгийг, сайн санаат хүн ард тийн хорт өвсийг жигшин зайлуулдгийг энэхүү шүүмжийн эцэст товч ч атугай тэмдэглэхийг миний бие өөрийнхөө эрхэм үүрэг гэж үзлээ.

Ц.БУРМАА